



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№ 01


Улаанбаатар хот

**Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх  
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг тус тус зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР



## МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

### Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай:
  - 1.1. Нийт хөрөнгийг 49,040,063,023.50 ( Дөчин есөн тэрбум дөчин сая жаран гурван мянга хорин гурван төгрөг тавин мөнгө ) -өөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 39,666,462,263.24 ( Гучин есөн тэрбум зургаан зуун жаран зургаан сая дөрвөн зуун жаран хоёр мянга хоёр зуун жаран гурван төгрөг хорин дөрвөн мөнгө ) -өөр;
  - 1.2. Өр төлбөрийн нийт дүнг 12,371,870,597.11 ( Арван хоёр тэрбум гурван зуун далан нэгэн сая найман зуун далан мянга таван зуун ерэн долоон төгрөг арван нэгэн мөнгө ) -өөр;
  - 1.3. Эзэмшигчийн өмчийг 36,668,192,426.39 ( Гучин зургаан тэрбум зургаан зуун жаран найман сая нэг зуун ерэн хоёр мянга дөрвөн зуун хорин зургаан төгрөг гучин есөн мөнгө ) -өөр тус тус баталсугай
2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№ 03


Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн  
талаарх дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6, 7.10, 7.16, 7.18 дахь заалт, 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан С.Цолмон, Ц.Норовжамц, Х.Баянбай нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс тус тус сонгосугай.
2. Ж.Тамир, Ю.Бат-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.
3. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№ 05


Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.


ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР



Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны  
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын  
№ 05 тогтоолын Хавсралт.



## ТУЗ-ИЙН 2023 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

/Нэгж: төгрөг/

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
<b>1. Цалин, холбоо, тээврийн зардал</b>					
1	ТУЗ-ийн гишүүний цалин	9	900,000	12	97,200,000
2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	620,000	12	7,440,000
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбооны зардал	1	150,000	12	1,800,000
	<b>Цалин, холбоо, тээврийн зардлын дүн</b>				<b>106,440,000</b>
4	Нийгмийн даатгалын шимтгэл				13,917,120
	<b>Дэд дүн</b>				<b>120,357,120</b>
<b>2. Бичиг хэрэг, хурлын зардал</b>					
1	Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал	1	150,000	12	1,800,000
2	Хурал зохион байгуулах байрны түрээс	1	200,000	2	400,000
3	Бусад зардал	1	100,000	5	500,000
	<b>Дэд дүн</b>				<b>2,700,000</b>
<b>3. ХХМТ-ийн салбар болон дэд бүтэц, бусад холбогдох салбарын туршлага судлах, хурал, үзэсгэлэнд оролцох, сургалтын зардал</b>					
1	Зөвлөх үйлчилгээ авах зардал	1	1,000,000	3	3,000,000
2	Сургалтын зардал	8	550,000	1	4,400,000
3	Тээврийн зардал	3	2,500,000	1	7,500,000
4	Зам хоног /5 өдөр/	3	145,000	4	1,740,000
5	Зочид буудал /5 өдөр/	3	435,000	4	5,220,000
	<b>Дэд дүн</b>				<b>21,860,000</b>
	<b>Нийт дүн</b>				<b>144,917,120</b>

Тайлбар: Энэхүү төсөв нь 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараа (2024) оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хамаарна.